

Эрүүл мэндийн газар

2025.01.09

1. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Бүсчилсэн сургалт

Эрүүл мэндийн байгууллагын чанар, аюулгүй байдал, халдварын сэргийлэлт, хяналттай холбоотой тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах эрүүл мэндийн Эрүүл мэндийн байгууллагын чанар, халдварын сэргийлэлт, хяналт, сувилахуйн багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх мэдээ мэдээллээр хангах зорилгоор Мөнххаан, Асгат, Онгон сумдад бүсчилсэн сургалтыг зохион байгуулсан.

Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал сургалт

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандах нийгмийн хандлагыг эергээр өөрчлөх, тэдэнд тулгарч буй нийгмийн болон орчны саад бэрхшээл, ялгаварлан гадуурхалтыг хэрхэн арилгах талаар “ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ТЭГШ БАЙДАЛ” сургалтыг АЗДТГ, ЭМГ, ХХҮГ, Шүүх хамтран зохион байгуулж, Сургалтын багшаар Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны дэд дарга Б.Болдбаатар ажиллалаа. Тус сургалтад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн гишүүд, төр захиргааны болон төрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын удирдлага, ажилтан, албан хаагч 100 хүн оролцсон.



Амилуулах суурь тусламж үзүүлэх сургалт

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтнүүдийн яаралтай тусламжийн үед үзүүлэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, багаар ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Амилуулах тусламж болон эмнэлэг хүртэлх яаралтай тусламж, талбарын эрэмбэлэн ангилалт”, “Тархины харвалтын үед үзүүлэх яаралтай тусламж, урьдчилан сэргийлэлт” сэдвүүдээр онол дадлага хосолсон сургалтыг АНЭ-тэй хамтран амжилттай зохион байгуулж, 19 байгууллагын 45 эмч, сувилагч хамрагдлаа.

Аян арга хэмжээ

“Мэдлэг олгоё, Нөлөөлье, Яг одоо” уриа дор “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх” дэлхийн 7 хоногийн аян зохион байгуулагдаж эрүүл мэндийн байгууллагууд оролцсон.

ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- Дэлхийн банкны санхүүжилтээр 1,4 тэрбум төгрөгийн өртөгтэй “G 14-3 иж бүрдэл “Компьютер томографын аппарат”-ыг нэгдсэн эмнэлэгт суурилуулан хүлээлгэн өгсөн.
- Түмэнцогт суманд 93 сая төгрөгийн өртөг бүхий Зөөврийн рентген аппаратыг Дэлхийн банкны санхүүжилтээр ЭМЯ-аас олгосон.



ТАЙЛАН МЭДЭЭ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ:

- МУ-н ерөнхийлөгчийн 73-р зарлиг ҮАБЗ-г мэдээллээр хангах журмын дагуу өдөр бүрийн 08:30 цагт эрүүл мэндийн мэдээллийг дээд шатны байгууллагад нэгтгэн хүргүүлж байна.
- Томуугийн харуулдан тандалтын 7 хоног бүрийн мэдээг 12 сум, 2 өрхийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгээс авч нэгтгэн хугацаанд нь ХӨСҮТ-д хүргүүлж байна.
- Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн биелэлтийг сар бүрийн 05-ны дотор цахим системээр аймгийн засаг даргын тамгын газарт хүргүүлж байна.
- Жилийн эцсийн тайланг АЗДТГ болон ЭМЯ-нд тухай бүр хүргүүлсэн.
- ЭМС-н тушаалын дагуу 2024 оны жилийн эцсийн үнэлгээг 12 сумын эрүүл мэндийн төв, 2 өрхийн эрүүл мэндийн төвд зохион байгуулсан.

Үндсэн хуулийн өдөр

Монгол Улсын анхдугаар Үндсэн хууль батлагдсаны 100 жил, шинэ Үндсэн хууль батлагдсаны 32 жилийн ой, “Монгол Улсын Үндсэн хуулийн өдөр”-ийн хүрээнд Эрүүл мэндийн газрын Ёс зүйн дэд хорооноос Үндэсний бичгээ “Хайрлая-Хамгаалъя-Хүндэтгэе” арга хэмжээг зохион байгуулсан.



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээн

Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/27, А/25 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Эрүүл Шүд” арга хэмжээний хүрээнд 13-15 настай хүүхдүүдийн дунд “Сургуулийн орчинд хүүхдийг эрүүл дадалтай болгох, “Шүд амны хөндийн болон гарын эрүүл ахуйн” боловсрол олгох, шүд угаах аргачлалыг эзэмшүүлэх, сургуулийн эмч, багш, эцэг эх асран хамгаалагчдын эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлж, шүд угаах зөв аргачлалыг эзэмшүүлэх, хүүхэд нэг нэгэндээ зааж сургах, шүд угаахын ач холбогдлыг олон нийтэд таниулах, эрүүл зан үйл төлөвшүүлэх” зорилгоор “ШҮД УГААЛТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН”-ийг Монголын шүдний эмч нарын холбооны дэмжлэгтэйгээр 5 өртөөгөөр 2024.10.28-нд зохион байгуулсан.



“ДЭВЖЭЭ” ТЭМЦЭЭН

ХДХВ, ДОХ-той тэмцэх дэлхийн өдрийг тохиолдуулан “Хүний эрхийг дээдлэн, зөв чигт урагшиль” уриа дор ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх өсвөрийн эрүүл мэндийн клубийн хүүхдүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол, бэлгийн замаар дамжих халдварт өвчний талаар мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зорилгоор “ДЭВЖЭЭ ТЭМЦЭЭН”-ийг 5 төрлөөр зохион байгуулсан. Тэмцээнд Асгат, Баяндэлгэр, Дарьганга, Баруун-Урт сумын ерөнхий боловсролын сургуулийн 7 багийн 35 сурагчид оролцсон.



ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭ

1. Оюутны эрүүл мэндийг дэмжих аян

Аяны хүрээнд үзлэг шинжилгээ, оношилгоонд нийт 171/171/100% оюутан, сурагчид хамрагдсан. Оюутан сурагчдыг ДОХ, тэмбүү, хеликобактер, В,С вирус шинжилгээнд хамруулсан. Үр дүнд: ДОХ, Тэмбүү, В, С вирус эерэг илрээгүй. Хеликобактер 171/71/41.5% эерэг илэрсэн.

-Нөхөн үржихүйн эрүүл мэнд, Гэр бүл төлөвлөлт, Электрон тамхины хор нөлөө, Дэлгэцийн донтолт, ЭМД төлөлтийн ач холбогдол зэрэг сэдвүүдээр танхимын сургалт зохион байгуулж 55 оюутан сурагч хамрагдсан. Гарын авлага брошур 2 төрлөөр 110 ширхгийг тараасан.



2. Жендэр

ЖСХТ 16 хоногийн аянд нэгдэн Энэрэл-ачтан ӨЭМТ, Энхлэн-Ачтан ЭМТ-тэй төрийн байгууллагуудад 3 сэдвийн хүрээнд танхимын сургалтыг зохион байгуулж, 28 албан хаагчид хамрагдсан. Мөн эрүүл мэндийн газрын хамт олон аянд нэгдэн бусад байгууллагыг уриалан ажилласан.



3. Элэг бүтэн монгол хөтөлбөр

Элэг бүтэн монгол хөтөлбөрийн хүрээнд Элэг бүтэн монгол хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Онгон, Асгат, Мөнххаан сумдад бүсчилсэн сургалтын сургагч багшаар ажиллаж 72 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдаж 2 төрлийн 144 ширхэг гарын авлагыг тараасан.

4. Гепатитгүй Сүхбаатарчууд төсөл

“Гепатитгүй Сүхбаатарчууд төсөл”-н хүрээнд Мөнххаан, Уулбаян, Түвшинширээ, Сүхбаатар, Наран, Дарьганга, Эрдэнэцагаан зэрэг 7 сумын Элэгний в, с вирусийн шинжилгээнд хамрагдаагүй 3168 иргэний нэгдсэн дата мэдээлэл дээр сумын багийн дарга нар болон эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтнүүдтэй хамтран ажилласан. Үүний хүрээнд сумандаа байгаа 249 иргэнийг дуудаж, в вирус эерэг-15, с вирус эерэг-10 илрүүлсэн.




5. Хаалганаас хаалганд сүрьеэгийн үзлэг

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй "Монгол Улсын ДОХ, сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, тусламж үйлчилгээний үндэсний тогтолцоог бэхжүүлэх" хөтөлбөрийн хүрээнд “Хаалганаас хаалганд” сүрьеэгийн идэвхтэй илрүүлэг үзлэгийг хиймэл оюун ухаанд суурилсан зөөврийн рентген аппаратыг ашиглан 6 суманд зохион байгуулсан.

Томуу томуу төст өвчин:

Улирлын томуу болон цартахлын эрсдэлийн үнэлгээгээр амбулаторийн үзлэг 10,000 хүн амд 162.4 тохиолдол, АЗЦХӨ-ийн 10,000 хүн ам дах өвчлөл 18.0 байна. Тархалтын түвшин **АЙМГИЙН ХЭМЖЭЭНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕД** шилжсэн байна.



1. Аймгийн засаг даргын захирамжаар аймгийн хэмжээний дэгдэлтийн түвшинд хүрсэнтэй холбогдуулан Баруун-урт, Эрдэнэцагаан, Баяндэлгэр, Мөнххаан, Онгон, Халзан, Түмэнцогт сумдын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэг, өдөр өнжүүлэх төвүүдийн үйл ажиллагааг 2025.01.02-ны өдрөөс эхлэн 2025.01.20-ний өдрийг хүртэл түр хугацаагаар хязгаарласан.
2. Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөц: 2024 оны байдлаар Эм тариа 22 нэр төрлийн - 473 сая төгрөг / 21-30 хоног/, Антибиотик 9-н нэр төрлийн -26,2 сая төгрөг / 14-21 хоног/, Вирусийн эсрэг эм, тариа 8 нэр төрлийн - 194 сая төгрөг /14-20 хоног/, Эмнэлгийн хэрэгсэл 13-н нэр төрлийн -19.8 сая төгрөг /14-21 хоног/, ХХХЭрэгсэл 10-н нэр төрлийн 48,2 сая төгрөг /21-30 хоног/, АХБодис 7-н нэр төрлийн - 21,6 сая төгрөг /10-14 хоног/-ийн нөөцтэй байна.
3. Харьяа өрхийн эрүүл мэндийн төвүүд гэрийн эргэлтийн болон уртасгасан цагаар ажиллах эмч, ажилчдын хуваарь гарган даваа- баасан гаригт 17⁰⁰-19⁰⁰ цаг хүртэл амралтын өдрүүдэд 10-14 цагийн хооронд эмч ажилчид ажиллаж байна. 2025 оны 01 дүгээр сарын 09-ны байдлаар 199/122/61% ТТӨ- байна.
4. Томуу томуу төст өвчний нөхцөл байдал, эмнэлзүй оношилгоо эмчилгээ, лаборатори, томуугийн дархлаажуулалт мэдээ тайлан өгөх чиглэлээр Зудаагийн цахим сургалт зохион байгуулж 126 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.
5. Аймгийн нэгдсэн эмнэлэгт хүүхдийн батлагдсан ор-44 одоо хэвтэн эмчлүүлж байгаа 139 үүнээс АЗЦХӨ-шалтгаантай 134 хэвтэн эмчлүүлж байна. Нэмэлтээр мэдрэлийн тасаг-24, сэргээн засах эмчилгээний тасаг-36, халдвартын тасаг-23, ур чадварын өрөөнд-12, нийт 95 ор дэлгэсэн. Эрдэнэцагаан сумын эрүүл мэндийн төв 6 ор нэмэлтээр дэлгэн ажиллаж байна.
6. ХӨСҮТ-ийн вирус судлалын лабораторид 24 сорьц тээвэрлэж адиновирус, риновирус, Sars-cov2 илэрсэн байна. ТТӨ-ний тандалтыг түргэвчилсэн гуравласан тестээр нийт 134 хэвтэн эмчлүүлэгчдэд Sars-Covid-2, А,В хэв шинж тодорхойлогдсон.
7. Хүүхдийн тасагт ТТӨ нэмэгдсэнтэй холбоотой хүний нөөцийг тодотгол хийж ажиллаж байна. Хүүхдийн тасагт их эмч-3 нэмэлтээр 2 их эмч, Сувилагч-8, нэмэлтээр-7 сувилагч, туслах сувилагч-3, өдрөөр тасагт-5, оройгоор -4 сувилагч, асрагч-3 ажиллаж байна. Халдвартын тасагт 15-р нэмэлтээр 10 ор дэлгэсэн. Халдвартын тасагт хүүхдийн их эмч-2, сувилагч- 4 нэмэлтээр ажиллаж байна.

8. Эрүүл мэндийн байгууллагууд томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх тухай нийт 4 сэдвээр 17 удаа 184 хэвтэн эмчлүүлэгчид сургалт хийгдсэн.
9. ЭМЯ-аас 5150 ширхэг осельтамивир эмийг хувиарласаны дагуу эрүүл мэндийн байгууллагуудад хувиарлах үйл ажиллагаа хийгдэж байна.
10. ТТӨ-ний нөхцөл байдалтай холбогдуулан сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад ажиллах хувиар гарган аймгийн төвийн цэцэрлэгүүдэд ажилласан. ТТӨ-ний чиглэлээр сургалтыг 11 цэцэрлэгийн нийт 192 багш ажилтнуудад зохион байгуулсан. Мөн эрүүл ахуй халдвар хамгааллын чиглэлээр зөвлөн туслаж хамтран ажилласан.



11. Томуу, томуу төст өвчний талаарх мэдээ, мэдээлэл эрүүл мэндийн газрын фэйж хуудас болон орон нутгийн “BBS” телевизийн эфирээр гарсан мэдээлэл

	Сэдэв	Үзсэн хүний тоо	Төрөл
1	Гараа савандаж угаацгаая	1372 хүн	Постер
2	Гараа савандаж угаацгаая	622 хүн	Постер
3	Хайртай хүмүүсээ хамгаалж маскаа зүүгээрэй	1575 хүн	Постер
4	#МаскааЗүүе	1141 хүн	Бичлэг
5	Автобус, нийтийн тээврээр зорчихдоо амны хаалтаа тогтмол зүүцгээгээрэй	3400 хүн	Бичлэг
6	Агаарын бохирдол, амьсгалын замын халдварт өвчлөлөөс амны хаалт хамгаална. Иргэн бүр амны хаалтаа зүүх нь эрсдэлээс сэргийлэх энгийн арга #МаскааЗүүе	1017 хүн	Бичлэг
7	Маск бол СОНГОЛТ биш СОЁЛ	1884 хүн	Постер
8	Хариуцлагатай хүний хэрэглээ #MACK	475 хүн	Постер
9	Амны хаалтыг хамар, ам, эрүүг далдлан завсар гаргахгүйгээр зүүж хэвшээрэй. Томуу, томуу төст өвчнөөс сэргийлье.	1210 хүн	Постер
10	Амны хаалтаа зүүж, гараа савантай усаар тогтмол угаагаарай.	6500 хүн	Шторк
11	Сургуулийн орчинд АМНЫ ХААЛТ зүүж томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлцгээе	9400 хүн	Шторк
12	Амны хаалтаа, маскаа сайн зүүж томуугаас сэргийлье	483 хүн	Бичлэг
13	ИРЭХ 7 ХОНОГТ ТОМУУГИЙН ДЭГДЭЛТ ОРГИЛ ҮЕДЭЭ ХҮРЭХИЙГ АНХААРУУЛЖ БАЙНА	1715 хүн	Постер
14	Томуу, томуу төст өвчний үед иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх утас	22250 хүн	Постер

15	ӨЭМТ-үүдийн цагийн хуваарь	5336 хүн	Мэдээ
16	Хайртай хүмүүсээ хамгаалж МАСКАА ЗҮҮГЭЭРЭЙ	1516 хүн	Постер
17	Маскаа зүүж, гараа угааж халдварт өвчнөөс урьдчилан сэргийлцгээе	1995 хүн	Постер
18	Аймгийн Засаг даргын захирамж	1799 хүн	Захирамж
19	Гараа тогтмол савандаж угаан, халдварт өвчнөөс сэргийлье.	1875 хүн	Шторк
20	Цар тахлын үнэлгээ	1673 хүн	Постер
21	Томуу томуу төст өвчний нөхцөл байдал	12000 хүн	Мэдээ

Сургалт, сурталчилгаа

- Тогооч нарын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, харилцан туршлага судлах, технологийн карт, өвчтөнд тохирсон эмчилгээний хоолоор үйлчилж, хоол хүнсээр дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилготойгоор эрүүл мэндийн салбарын 24 тогооч нарт “Хүнсний аюулгүй байдал ба шим тэжээл” сургалтыг зохион байгууллаа.



- Эрүүл монгол хүн хөтөлбөрийн хүрээнд 6 байгууллагын 291 ажилтан албан хаагч, иргэдэд Өглөөний цай уухын ач холбогдол, Эрүүл урт наслалт-Эрүүл зохистой хооллолт, Энэ жилдээ-Эрүүл жиндээ байх арга, Эмэгтэй таны эрүүл мэнд-Эрүүл хооллолтоос” сургалтуудыг зохион байгуулсан.
- **Хог хаягдлын ажилтан бэлтгэх сургалт:** Халдварын сэргийлэлт хяналтын тогтолцоог бэхжүүлэх эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлын ажилтан бэлтгэх, чадавхжуулах сургалтыг 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр эрүүл мэндийн газар зохион байгуулсан. Сургалтад 19 байгууллагын холбогдох мэргэжилтнүүд хамрагдаж, батламж гардан авсан.
- **Элэг бүтэн монгол хөтөлбөрийн** хүрээнд тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх, хөтөлбөрийн үр дүнг тооцох, тархалтыг тодорхойлох сургалт
Аймгийн хэмжээнд вируст гепатитын тархалтыг тодорхойлох, дата мэдээлэл дээр ажиллах, судалгааны арга зүйд суралцах зорилгоор тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх, хөтөлбөрийн үр дүнг тооцох, тархалтыг тодорхойлох сургалтыг Аймгийн нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, өрх, сумын эрүүл мэндийн төвийн 20 эмч, мэргэжилтэнд 2024 оны 12 дугаар сарын 11-13 өдрүүдэд зохион байгуулсан.
- 2024 оны 4 дүгэр улиралд нийт 86 байгууллагын 2300 иргэнд сургалт хийсэн байна. Орон нутгийн BBS телевизээр 10 төрлийн мэдээ 15 төрлийн шторк бэлтгэн түгээсэн байна. Нэг мэдээлэл дунджаар 9000 орчим үзэлт хандалттай байна.

**ОРОН НУТГИЙН “БИ БИ ЭС” ТЕЛЕВИЗЭД
ӨГСӨН МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ**

2024 оны 10 дугаар сар

Эфирт өгсөн огноо	Төрөл	Сэдэв	Хугацаа
2024.10.14	Шторк	“Хүүхдийн аюулгүй байдал - Таны хариуцлагаас”	51сек
2024.10.14	Шторк	“Эрүүл мэндийн мэдээлэл ба анхны тусламж”	1минут
2024.10.14	Шторк	Эм бол Хоол биш”	1минут
2024.10.14	Шторк	“Хүнсний аюулгүй байдал”	1минут
2024.10.14	Шторк	“Зөв зохистой хооллолт”	24сек
2024.10.26	Мэдээ	“Амилуулах тусламж болон Тархины харвалт сургалт”	2минут
2024.10.29	Мэдээ	“Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээн”	2минут

2024 оны 11 дүгээр сар

Эфирт өгсөн огноо	Төрөл	Сэдэв	Хугацаа
2024.11.02	Нээлт live	“Эрүүл мэндийн салбарын спортын V наадам”	1 цаг
2024.11.03	Мэдээ	“Эрүүл мэндийн салбарын спортын V наадам”	2 минут
2024.11.09	Шторк	“Дархлаа дэмжих цэгэн иллэг”	3 минут
2024.11.09	Шторк	“Томуу өвчнөөс урьдчилан сэргийлэх”	1 минут
2024.11.09	Шторк	“Ханиадаа гэрийн нөхцөлд намдаах”	40 сек
2024.11.09	Шторк	“Ханиад шөнө яагаад хүндэрдэг вэ”	1 минут
2024.11.09	Шторк	“Авлигын эсрэг аянд нэгдэж байна”	54 сек
2024.11.11	Мэдээ	“Хүний папиллома вирус, Халдварын дархлаажуулалт	2 минут
2024.11.14	Мэдээ	“Чихрийн шижинтэй тэмцэх өдөр”	2 минут
2024.11.25	Шторк	“Папиллома вирусээс сэргийлэх” Яриа: Эмч Мөнхзул	1минут
2024.11.27	Шторк	“Папиллома вирусээс сэргийлэх” Яриа: Сэтгүүлч Одончимэг	1минут

2024 оны 12 дугаар сар

Эфирт өгсөн огноо	Төрөл	Сэдэв	Хугацаа
2024.12.04	Мэдээ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг “Хүртээмжтэй, тогтвортой ирээдүйн төлөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн манлайллыг нэмэгдүүлье” уриатайгаар тэмдэглэж байна.	12 м 350 хүн
2024.12.04	Мэдээ	Аймгийн хэмжээнд хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтыг 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн зохион байгуулан хуваарийн дагуу ажиллаж байна.	3м 1,4 мян
2024.12.06	Шторк	Үе тэнгийн найзуудаа дархлаажуулалтдаа идэвхтэй хамрагдаарай	47 сек 9,6 мян

2024.12.06	Мэдээ	Амбулаториор 5821 хүн үйлчлүүлсний 871/15% -г томуу, томуу төст өвчин (ТТӨ) эзэлж, өмнөх долоо хоногоос 0.6%-аар өссөн. ТТӨ-ний нийт тохиолдлын 871/725(83.2%)-ийг 0-14 хүртэлх насны хүүхдүүд эзэлж байгаагийн 489/67.4%-ийг 0-4 хүртэлх насны хүүхдүүд эзэлж байна.	6м 37с 13 мян
2024.12.09	Шторк	АВЛИГЫН ЭСРЭГ ХАМТДАА НЭГДЬЕ	47 с 600 хүн
2024.12.27	Мэдээ	Томуу, томуу төст өвчин ихсэж байгаатай холбоотойгоор Өрхийн эмнэлгүүд уртасгасан цагаар ажиллаж байна....!!	2м 05с 1,4 мян
2024.12.26	Мэдээ	ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ТАЛААР...	17м 21с 12 мян
2024.12.31	Шторк	Хүүхдүүд ээ... гараа тогтмол савандаж угаан, халдварт өвчнөөс сэргийлье.!!	1м 21с 21 мян

Дархлаажуулалт:

- ЭМС-ын 2024 оны А/455 тушаал, АЗД-ын захирамж 2024 оны А/629 “Хүний папиллома вирусийн халдварын эсрэг товлотл дархлаажуулалт зохион байгуулах тухай”, ЭМГ-ын даргын 2024 оны А/94 “Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” тушаалуудыг үндэслэн аймгийн хэмжээнд 11 настай охид, хөвгүүдийг Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинд хамруулан, дархлаажуулалтын хамралт 40 хувьтай хийгдэж байна.
- Мөн Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн сан, Аймгийн засаг даргын тамгын газартай хамтран “Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтыг эрчимжүүлэх үйл ажиллагааны төлөвлөө”-г боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- ХӨСҮТ-тэй хамтран “Хүний папиллома вирусийн эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааны хүрээнд бэлтгэл ажлыг хангах” нь сэдэвт сургалтыг АЗДТГ, БШУГ, Ерөнхий боловсролын сургуулиудын нийгмийн ажилтан эмч, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, вакцинатруудын төлөөллийг оролцуулсан 2 өдрийн сургалтыг нийт 68 хүнд зохион байгуулсан.
- ЭМС-ын 2024 оны А/359, ЭМГ-ын даргын 2024 оны А/73 “Улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” тушаалын хэрэгжилтийг хангуулах зорилгоор дархлаажуулалтын 10 хоногийг зохион байгуулан ажилласан. Аймгийн хэмжээнд томуугийн эсрэг вакцинд эрсдэлт бүлгийн хүн амын тодорхой хувийг буюу жирэмсэн эмэгтэй, архаг хууч өвчтэй хүн, 65-аас дээш насныхан, эрүүл мэндийн байгууллагын ажилчид, 6 сараас 5 хүртэлх насны хүүхдүүдийг томуугийн эсрэг дархлаажуулалтад 100% хамруулан ажилласан байна. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл илрээгүй.



Спортын наадам

Эрүүл мэндийн салбарын спортын 5-р наадмыг зохион байгуулан, 14 байгууллагын 210 гаруй тамирчид ганцаарчилсан болон багийн спортын 5 төрөлд хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.



Гамшиг

Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын 2024 оны Өвөлжилтийн бэлтгэл ажил хангах талаар авах арга хэмжээний тухай 103 дугаар тушаалын дагуу Аймгийн Засаг даргын 2024 оны А/671 дүгээр захирамжаар аймгийн “Шуурхай штаб”-ыг 12.03-ны өдрөөс Хүнс хөдөө аж ахуйн газарт, мөн 13 сумдын хэмжээнд “Шуурхай штаб” байгуулан ажиллаж байна. Шуурхай штабын жижүүрийн бүрэлдэхүүнд /ХХААГ, ОБГ МЭГ, ХХҮГ, УЦУОШТ, ЭМГ/- тус тус алба хаагчид үүрэг гүйцэтгэж, өдөр бүрийн 17:30 цагт сумдаас өвөлжилтийн болон томуу, томуу төст өвчний дэгдэлтийн мэдээг нэгтгэн авч ажиллаж байна.

Тайланг нэгтгэсэн: ХШҮДАХ мэргэжилтэн Д.Саранзаяа

